



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 3 сарын 19 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт зохион байгуулах,
гэрчилгээ олгох журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1.“Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээлэл”-ийн маягтыг 2 дугаар хавсралтаар, “Сонгуулийн хороодод ажиллах ажилтны гэрчилгээ”-ний загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг ханггуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам батлах тухай” 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 3.. дугаар сарын 19.. ны өдрийн
10.. дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**СОНГУУЛИЙН ХОРООДОД АЖИЛЛАХ АЖИЛТНЫ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн хороодод ажиллах ажилтнуудад сонгуулийн хууль тогтоомжийн талаар сургалт /цаашид “сургалт” гэх/ зохион байгуулах, гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сургалтад төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч /цаашид “төрийн албан хаагч” гэх/ хамрагдана.

1.3. Сургалтын хөтөлбөрийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга батална.

1.4. Сонгуулийн тухай хууль тогтоомж шинэчлэн батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд сургалтын хөтөлбөрийг шинэчилж, гэрчилгээ авсан төрийн албан хаагчдыг энэ журамд заасны дагуу давтан сургалтад хамруулж болно.

**Хоёр. Сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын
мэдээлэл хүлээн авах, бүртгэх**

2.1. Сонгуулийн ерөнхий хороо сургалтад хамрагдах төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдыг бүртгэх, сургалт зохион байгуулах тухай өөрийн цахим хуудсаар мэдээлнэ.

2.2. Сургалтад хамрагдах төрийн албан хаагч хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, эсхүл, сонгуулийн хороодод хүргүүлнэ. Хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

2.2.1. иргэний үнэмлэхийн хуулбар;

2.2.2. төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалд томилсон шийдвэрийн хуулбар.

2.3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сонгуулийн хороод өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд сургалтад хамрагдах албан хаагчдын мэдээлэл, баримт бичгийг нэгтгэж, Сонгуулийн ерөнхий хороонд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.4. Төрийн албан хаагч сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтад хамрагдах хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсаар дамжуулан гаргаж болно.

2.5. Сонгуулийн ерөнхий хороо сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээллийг хүлээн авч, бүртгэн, баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр хадгална.

2.6. Төрийн албан хаагчийн бүртгэлийн мэдээлэл, хавсаргах баримт бичиг дутуу бол энэ тухай ирүүлсэн этгээдэд мэдэгдэх бөгөөд мэдээлэл, баримт бичгийг сургалт зохион байгуулахаас өмнө нөхөн ирүүлж болно.

2.7. Сонгуулийн хороод доод шатны сонгуулийн хороодыг байгуулах үед гэрчилгээтэй төрийн албан хаагчдын нөөц хангалтгүй тохиолдолд сургалтад хамруулах төрийн албан хаагчдын мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.8. Сонгуулийн ерөнхий хороо энэ журамд заасны дагуу хүлээн авсан төрийн албан хаагчдын мэдээлэл, баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр хадгална.

Гурав. Сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох

3.1. Сургалтыг дараах этгээд зохион байгуулна.

3.1.1. Сонгуулийн ерөнхий хороо;

3.1.2. аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба;

3.1.3. аймаг, нийслэлийн сонгуулийн хороо;

3.1.4. сум, дүүргийн сонгуулийн хороо.

3.2. Сургалтыг энэ журмын 3.1-д заасан этгээд зохион байгуулахдаа сургалт зохион байгуулах эрх бүхий дүрэмтэй төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.

3.3. Сургалтыг аймаг, дүүрэгт, эсхүл бүсчилсэн байдлаар танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

3.4. Энэ журмын 3.1.2-3.1.4-т заасан этгээд сургалт зохион байгуулахдаа Сонгуулийн ерөнхий хороонд урьдчилан мэдэгдэх бөгөөд сургалт зохион байгуулсан тухай тайлан, холбогдох баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

3.5. Сонгуулийн ерөнхий хороо сургалт зохион байгуулах сонгуулийн хороодыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.6. Сонгуулийн ерөнхий хороо сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдад гэрчилгээ олгоно.

3.7. Гэрчилгээ нь улсын хэмжээнд нэгдсэн дугаар, тусгай нууцлалтай байна. Гэрчилгээг гээгдүүлж, үрэгдүүлсэн тохиолдолд нэг удаа нөхөн олгож болно.

3.8. Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтыг зохион байгуулахад тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Хариуцлага

4.1. Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 3 дугаар сарын 10.-ны өдрийн
10. дугаар тогтоогийн 2 дугаар хавсралт

СОНГУУЛИЙН ХОРООНД АЖИЛЛАХ АЖИЛТНЫ СУРГАЛТАД ХАМРАГДАХ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн
10 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



СОНГУУЛИЙН ХОРООД ДАЖИЛЛАХ АЖИЛТНЫ
ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО



ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

.....-ны нь /РД:/

сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтад хамрагдсан тул

ГЭРЧИЛГЭЭ олгов.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
дарга /
/тамга/

20 ... оны дугаар сарын-ны өдөр

Тайлбар: Гэрчилгээ нь нэгдсэн дугаартай, тусгай нууцлалтай байна.